

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН 2018 ОНЫ ТАЙЛАН МЭДЭЭ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2018 онд иргэд, аж ахуйн нэгжээс нийт 257 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс бичгээр 183, 11-11 төвөөр 72, утсаар 2, өргөдөл гомдол санал хүсэлт ирснийг хүлээн авч зохих хариу өгч ажиллаа.

2018 онд ирсэн нийт өргөдлийг агуулгаар авч үзвэл 78 буюу 30,3 хувь нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын ажилтай холбоотой санал, хүсэлт, 66 буюу 25,6 хувь нь салбарын холбогдолтой асуудлаар ямар нэг дэмжлэг, тусламж хүссэн, 27 буюу 10,5 хувь нь салбарын шагналтай холбоотой асуудал, 11 буюу 4,2 хувь нь ажилд орохыг хүссэн өргөдөл байна. Мөн энэ онд 28 гомдол ирсэн бөгөөд нийт өргөдлийн 10,8 хувийг эзэлж байна.

2018 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлт 96,8 хувьтай байна.

Иргэдийн өргөдөл гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэж хариу өгөх, ажлын байранд, ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглосон заалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журманд тусгасан.

Яамны харьяа байгууллагуудад иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэх, ажилтнуудын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах талаар 2018 оны 04 сарын 19-ны өдрийн 01/1325 тоот албан бичиг хүргүүлж ажиллаа.

2018 оны 1 дүгээр улиралд Авлигатай тэмцэх газраас шалгалт ирж 2017, 2018 оны эхний улирлын өргөдөл гомдлын тайлан, бүртгэл, шийдвэрлэлтийг нэг бүрчлэн үзэж шалгаж, зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаа.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх ажлын хүрээнд яамны өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй танилцаж зохих үнэлгээ өглөө.

2018 онд яамны ажилтнуудаас яамны удирдлагад гаргасан 109 өргөдлийг хууль журмын дагуу шийдвэрлэсэн болно.

**2018 ОНД ИРГЭДЭЭС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомд лын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
		Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	257	249	5	-	3	96,8

**2018 ОНД ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ**

Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс					
		Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	257	183	72	-	2	-	-

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо, /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2018 онд ирсэн нийт өргөдлийг агуулгаар авч үзвэл 78 буюу 30,3 хувь нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын ажилтай холбоотой санал, хүсэлт, 66 буюу 25,6 хувь нь салбарын холбогдолтой асуудлаар ямар нэг дэмжлэг, тусламж хүссэн, 27 буюу 10,5 хувь нь салбарын шагналтай холбоотой асуудал, 11 буюу 4,2 хувь нь ажилд орохыг хүссэн өргөдөл байна. Мөн энэ онд 28 гомдол ирсэн бөгөөд нийт өргөдлийн 10,8 хувийг эзэлж байна.

.....оОо.....

